

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Эрдэнэ сүмын төвийн нарны зайн, цамхагт гэрэлтүүлгийн угсралтын ажил:

A. Ажил гүйцэтгэх хугацааны график /ходолмор зарцуулалт, ургэлжлэх хугацаа, ажиллах хүчиний тоо/-ыг тодорхой гаргаж ирүүлнэ. Мөн ажлыг гүйцэтгэх технологи аргачлал, техникийн тодорхойлолтыг боловсруулж ирүүлнэ.

B. Нарны зайн гэрэлтүүлэгийн угсралтын ажлыг норм дүрэм, журам стандартыг баримтлан технологийн дагуу чанартай гүйцэтгэх.

C. Төндөрийн үнийн саналд зохиогчийн хяналтын зардалыг захиалагчийн хяналтын зардлын 50 хувиар, зураг төслийн нэ 1780900 төгрөгийг тус тус тусгаж ирүүлнэ.

1. Нарны зайн гэрэлтүүлэгийн ажил нь:

-Бүх угсралтын ажлыг гүйцэтгэхдээ цахилгаан байгууламжийн дүрэм БД43-101-03, цахилгаан техник угсралтын БНБД3.05.06-90, □Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг□ БНБД 23-02-08, цахилгааны аюулгүй ажилгааны дүрэм зэргийг мөрдлөг болгоно. Нарны зайн гэрэлтүүлгийг зураг төсөлд заасны дагуу чанартай хийж гүйцэтгэнэ.

- Шонгийн суурин нүхийг гар аргаар ухаж М100 маркийн бетон бэлтгэл дээр М150 маркийн суурин гүйцэтгэхдээ цахилгааны аюулгүй ажилгааны дүрэм зэргийг мөрдлөг болгоно. Нарны зайн гэрэлтүүлгийг зураг төсөлд заасны дагуу чанартай хийж гүйцэтгэнэ.

- Гэрэлтүүлэг газрын хөрснөөс 5м өндөр, нэг толгойтой, гэрэлтүүлэгчийн чадал 50ватт цэгэн гэрэлтэй лед гэрэл байна.

- Нарны зайн гэрэлтүүлэг удирдлагын релей /харанхуйг мэдрэх мэдрэгч/-тэй байна.

- Гэрэлтүүлгийн шон нь цайрдсан зэвэрдэггүй төмөр, уртаашаа нэг талаар нь гагнуураар оёсон хийцтэй байна. Шонгийн хана нь 4 мм-с багагүй зузаантай, ф нь 70-120 мм байна.

Төндөрт шалгарсан гүйцэтгэгч нь: импортын материал сонгон худалдан авах тохиолдолд тохирлын гэрчилгээ, сертификат, паспорт, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргана. Үндэсний үйлдвэрийн материал сонгон авбал „Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ,, лабораторийн шинжилгээний дүн, падаан хавсаргана.

Угсралтын ажлыг чанаргүй хийсэн тохиолдолд өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгөх бөгөөд гүйцэтгэсэн ажилдаа Барилгын тухай хуулийн 14.3, 14.6-д заасны дагуу чанарын баталгаа гаргаж өгнө.

Хэрвээ барилгын зураг төсөвт өөрчлөлт оруулах, материал хийц өөрчлөх тохиолдолд хүсэлтээ захиалагч байгууллагад бичгээр гаргаж хүсэлт гаргасан өдрөөс 7 хоногийн дотор хариу өгнө. Зөвшөөрөөгүй тохиолдолд зураг төсвийн дагуу гүйцэтгэнэ.